



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/195

Булган сум

Ой, ойн санд аж ахуйн үйл ажиллагаа
явуулахыг түр хориглох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.18, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, Засгийн газрын 2013 оны “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх журам” 106 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2025 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний удирдамж” 01 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын онцгой комиссын 2025 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгаврын дагуу түймрийн аюултай үед ой, ойн сан бүхий газарт аялах, ан агнах, Бугын эвэр түүх, мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр, 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл тус тус хориглосугай.

2. Дээрх хугацаанд түймрийн аюулын зэрэглэл, I-II зэрэглэлд хүрч буурсан үед иргэн, хуулийн этгээдүүд ой, хээрийн гал түймрээс хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, мод бэлтгэл, ойн арчилгаа, цэвэрлэгээний үед түймрийн аюулгүй байдлыг хангахад тавигдах тусгай шаардлагыг хангаж, орон нутгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу ой, ойн сангаас мод бэлтгэх үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсүгэй.

3. Түймрийн аюултай үед сум орон нутагтаа Шуурхай штабын жижүүр ажиллуулж, аймгийн Онцгой байдлын газар, Байгаль орчны газарт тогтмол мэдээлж ажиллахыг сум дундын Ойн анги, сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4. Түймрийн аюулын ангилал, зэрэглэлийг өдөр бүр гаргаж, Онцгой байдлын газар, Байгаль орчны газар, сумын Засаг даргын Тамгын газарт мэдээлж ажиллахыг Ус цаг уур, орчны шинжилгээний төв (Б.Нандинбат)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Онцгой байдлын газар (дэд хурандаа Н.Хишигдорж), Байгаль орчны газар (А.Гантөмөр), сум дундын Ойн анги, сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Булган Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010285